

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН
ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ, ҮР ДҮН
(The Economic Impact of Tourism in Mongolia)

Л.Амартүвшин*
Н.Галиймаа*

Хураангуй

Аялал жуулчлалын салбар эдийн засагт хэрхэн нөлөөлж, ямар үр дүнд хүрч байгаа болон уг салбарын ололт, амжилт, дутагдлыг ямар хэмжүүрээр хэмжиж байгааг Монгол улсын жишээн дээр системтэйгээр харуулах зорилгоор энэхүү өгүүллийг бид бичлээ. Монгол улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хурдацтай өсч байгаа салбар нь аялал жуулчлал бөгөөд өнөөдөр эдийн засгийн тэргүүлэгч салбаруудын нэг болжээ. Ажлын байрны багтаамж ихтэй, гадаад валют олдог салбарын нэг төдийгүй орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд аялал жуулчлал чухал үүрэг гүйцэтгэх болсоор нэлээд хэдэн жилийг ардаа үджээ. Хэдийгээр энэ мэт олон талын зөрөг үүргийг улс орны хөгжилд гүйцэтгэдэг ч энэ салбарын сөрөг талыг мартаж болохгүй. Аялал жуулчлалыг онол, практик талаас авч үзэхдээ уг салбарын эдийн засагт оруулах хувь нэмрийн талаар тодорхой үнэлэлт, дүгнэлтүүдийг өгөхийн зэрэгцээ аялал жуулчлалын эдийн засагт гүйцэтгэх үр дүнг тооцох, түүнийг нэмэгдүүлэх зарим саналуудыг бид дэвшүүлсэн болно. Аялал жуулчлалын салбарын эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлохдоо Аялал жуулчлалын тусгай данс (TSAs)-ны аргыг Монгол улсын хэмжээнд анх удаа хэрэглэхийг хичээж байгаагаа уншигч Таны сонорт хүргэе.

Түлхүүр үг: Аялал жуулчлал, Аялал жуулчлалын эдийн засгийн үр дүн, Дотоодын нийт бүтээгдэхүүн, Аялал жуулчлалын тусгай данс (TSA)

Нэг. Оршил

1990 онд ардчилсан хувьсгал ялснаар Монгол улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон. Хорь гаруй жилийн хугацаанд зах зээлийн эдийн засгийн орчныг бүрдүүлэх, эдийн засгийг (үйлдвэрлэл, үйлчилгээг) эрчимтэй хөгжүүлэх талаар төрөөс тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж иржээ. Зах зээлийн эдийн засагт шилжин, нээлттэй эдийн засгийн бодлого баримталсны хүчинд харьцангуй хурдацтай хөгжиж буй салбаруудын нэг нь аялал жуулчлал юм. Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд шинээр хөгжиж байгаа тул ололт, амжилтын зэрэгцээ засаж залруулах олон зүйл аялал жуулчлалын салбарт байсаар байна.

* ШУТИС-Түүх, Аялал жуулчлалын профессорын баг

8158 км хилтэй Монгол улс БНХАУ, ОХУ гэсэн хоёр их гүрний дунд “буфер” улс болон оршдог бөгөөд далайд гарцгүй, өргөн уудам газар нутагтай, дэд бүтэц сул хөгжсөн, орон нутагт хүн амын нягтшил багатай нэгэн билээ. Нүүдлийн мал аж ахуй, онгон байгаль, түүх, соёлын арвин дурсгалтай, уламжлалт нүүдлийн соёлоо өнөөг хүртэл хадгалан үлдсэнээ зэрэг нь аялал жуулчлалын нөөц арвинтайг илтгэх бөгөөд эдгээр нөөцөөрөө олон улсын жуулчдын анхаарлыг татдаг. Эдгээр аялал жуулчлалын нөөцийг өнөөгийн аялал жуулчлалын зах зээлийн хэмжээтэй харьцуулбал Монгол улс жуулчин хүлээж авах зах зээлийн чадавхиа бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байна. Аялал жуулчлалын нөөцийг эргэлтэнд оруулснаар бүрэн дүүрэн ашиглах, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийг өсгөн нэмэгдүүлэх, шинээр бий болгосноор олон улсын аялал жуулчлалын зах зээлд байр сууриа бэхжүүлэн өсгөх замаар үндэсний эдийн засагт оруулах хувь нэмрийг дээшлүүлэх бололцоо Монгол улсад байна.

Манай улсын аялал жуулчлалын салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг Аялал жуулчлалын нэгдсэн дансны аргаар (TSAs) нэгтгэн дүгнэх нь бидний судалгааны ажлын зорилго юм. Түүнчлэн уг өгүүллэгийн хүрээнд аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх үр дүн, нөлөөллийн талаар судалсан зарим судлаачдын байр суурийг тодорхойлох, мөн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх талаар өөрсдийн саналыг дэвшүүлэн тавьж байна.

Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр дүнг тодорхойлох асуудлыг үндсэн хоёр чиглэлээр бид авч үзэв. Үүнд:

- Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дүнг тооцох талаар зарим судлаачдын үзэл баримтлалыг товч дурдах
- Аялал жуулчлалын салбарын манай улсын эдийн засгийн үзүүлэх нөлөө, үр дүнг Аялал жуулчлалын нэгдсэн дансны аргаар (TSAs) нэгтгэн дүгнэх

Хоёр. Аялал жуулчлалын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дүнг тооцох талаархи өнөөгийн үзэл баримтлалууд

Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тайлангаас үзэхэд 2010 онд олон улсын жуулчдын тоо 2009 онтой харьцуулахад 6,6% хувиар өссөнөөр дэлхийн бүх бүс нутагт эерэг буюу өсөлттэй гарсан байна. 2009 оны эдийн засгийн хямралаас болж 4% буурсан жуулчдын тоо ийнхүү өссөн бөгөөд энэхүү өсөлт 2011 онд 4-5% -тай байх магадлал буй нь аялал жуулчлалын ойрын ирээдүйн хандлагыг Та бүхэнд харуулах биз ээ. Олон улсын жуулчдын тоо 940 сая, салбарын орлого 919 тэрбум ам.долларт хүрсэн байна (UNWTO, 2011²). Дэлхийн Аялал, Жуулчлалын Зөвлөлийн тайланг харахад ажилтай арван тутмын нэг нь аялал жуулчлалын салбарт ажиллаж байна. Салбарын нийт ажил эрхлэгчдийн тоо 258 саяд хүрч байгаа бөгөөд дэлхийн нийт бүтээгдэхүүний (global GDP) 9,1% -ийг үйлдвэрлэж байна (WTTC, 2011³).

Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн нөлөө, үр дүнг тооцох зорилгоор 2000 онд гаргасан Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага, НҮБ-ээс хүлээн зөвшөөрөгдөж, Аялал Жуулчлалын Тусгай Дансны Аргыг (Tourism Satellite Accounts TSA) дэлхийн олон улс орнууд тогтмол ашигладаг (John Fletcher, 2008⁴). Тухайн улсын төдийгүй олон улсын түвшинд аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр дүнг хэмжих, харьцуулалт хийхэд энэхүү аргыг хэрэглэдэг бөгөөд эдийн засгийн үр дүнг тооцох уламжлалт аргуудыг бодвол илүү боловсронгуй, стандартчилагдсан, аялал жуулчлалын салбарын эдийн засгийн үр дүнг нэгтгэж авч үзэхэд илүү тохиромжтой байдаг. Аялал жуулчлалын салбарын эдийн засагт бий болгодог орлого, татвар, ажлын байр, цалин хөлсний түвшин, эдийн засгийн бусад салбарт үзүүлэх нөлөө, харьцуулалтыг TSA-гаар харуулж болно.

² World Tourism Organization (UNWTO). Available from online at <http://unwto.org/>

³ World Travel & Tourism Council (WTTC). Available from online at www.wttc.org

⁴ Chris Cooper, John Fletcher, Alan Fyall, David Gilbert & Stephen Wanhill (2008). Tourism: Principles and Practice, 4th edition. UK.

Аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг Америкийн судлаач Волкер (2010) дараах байдлаар илэрхийлсэн байдаг. Жуулчид аялсан орондоо зочид буудалд байрлах, үзвэр үйлчилгээнд хамрагдах, ресторанд хооллоход тодорхой хэмжээний зардал болох мөнгийг үлдээдэг. Энэхүү мөнгө нь тухайн орны эдийн засагт шууд оруулж байгаа орлого бөгөөд цаашид дахин эргэлтэнд орж өөр бүтээгдэхүүн, үйлчилгээний салбаруудыг дэмжихэд хэрэглэгддэгийг эдийн засгийн ухаанд үржүүлэгчийн нөлөө хэмээн нэрлэдэг. Сүүлийн үеийн судалгаануудаас үзэхэд үржүүлэгчийн нөлөө 1,5-2,0 хооронд (дэлхийн дундаж) байна (Walker, 2010⁵). Тиймээс аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөг тооцоходоо энэхүү үржүүлэгчийн нөлөөг давхар тооцох нь уг салбарын эдийн засгийн үр дүнг бүрэн дүүрэн гаргахад чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн аялал жуулчлалын салбар дахь төрийн оролцооны зохистой түвшинг тогтоох нь чухал байдаг. Женкинс, Хенри нар (Jenkins & Henry, 1982⁶) хөгжиж байгаа орнуудын аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнгийн талаар судалж үзээд аялал жуулчлалын салбар дахь төрийн оновчтой оролцоо нь салбарын эдийн засгийн үр дүнг өсгөхөд хүчтэй эерэг нөлөөг үзүүлж байгааг баримтаар тогтоожээ.

Тухайн орон нутагт гаргасан жуулчдын зардлын хэмжээгээр аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг тооцдог. Аялал жуулчлалын эдийн засгийн нийт үр дүнг тооцоходоо жуулчдын гаргасан нийт зардал, тухайн орон нутгийн эдийн засаг дахь үржүүлэгчийн нөлөөг мөн судалж, тооцож гаргах шаардлагатай. Нийт жуулчдын тоог нэг жуулчны дундаж зардлаар үржүүлж эдийн засгийн шууд үр дүн буюу тухайн орон нутагт аялал жуулчлалаас олсон орлогын хэмжээг тооцно. Аялал жуулчлалын эдийн засгийн нийт үр дүнг тооцоход дээрх шууд орлогод үржүүлэгчийн нөлөөг тооцож авч үздэг.

$$EALGA = VN * VS * RM$$

EALGA - Аялал жуулчлалын эдийн засгийн нийт үр дүн

VN - Жуулчдын тоо

VS - Нэг жуулчны дундаж зардал

RM - Үржүүлэгчийн нөлөө

Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн нийт үр дүнг дараах гурван хэсэгт хувааж авч үздэг. Үүнд шууд үр дүн (direct impact), шууд бус үр дүн (indirect impact) болон өдөөх үр дүн (induced impact) орно. Сүүлийн хоёр үр дүнг хамтатган хоёрдогч үр дүн гэж нэрлэх нь ч бий. Жуулчдын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг худалдан авахад гаргасан зардлыг шууд үр дүн гэдэг бөгөөд тухайн орон нутгийн аялал жуулчлалаас олсон шууд орлогыг илэрхийлдэг. Жишээлбэл тухайн зочид буудалд байрлах жуулчдын хоногийн тоо өсвөл тэр хэмжээгээр буудлын орлого өсөн нэмэгдэнэ. Тухайн жуулчдаас олсон орлогыг аялал жуулчлалтай холбогдох бусад салбарт зарцуулах тухайлбал зочид буудлын ресторанд хүнсний бүтээгдэхүүн авах, цахилгааны төлбөр төлөх зэргээр шууд бус үр дүн илэрнэ. Өөрөөр хэлбэл бусад салбаруудын бараа, үйлчилгээг худалдан авах байдлаар гарч байгаа зардлууд буюу тухайн мөнгө эдийн засгийн эргэлтийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон нэмүү үйлдвэрлэлийг шууд бус үр дүн илэрхийлнэ. Аялал жуулчлалаас олсон дээрх орлогуудын зарим хэсэг нь өрх гэрүүдэд цалин хөлс, ногдол ашиг байдлаар очих бөгөөд тэд энэхүү орлогоо өрх гэрийн хэрэглээнд зарцуулахыг буюу эдийн засгийн нэмэлт эргэлтийг бий болгож байгаа хэмжээг өдөөх үр дүн гэнэ. Эндээс үзэхэд жуулчдын гаргасан зардал нь эдийн засгийн эргэлтэнд орж тухайн орон нутгийн нийт үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг. Өнөөдөр НҮБ-ын статистик хариуцсан газраас Аялал Жуулчлалын Тусгай Дансны Аргыг (TSA:RFM) ашиглахдаа аялал жуулчлалын эдийн засгийн шууд үр дүн буюу эдийн засагт оруулах шууд хувь нэмрийг голлон тооцдог ч Дэлхийн Аялал, Жуулчлалын Зөвлөлөөс аялал жуулчлалын шууд бус хувь нэмрийг тооцох нь чухал ач холбогдолтой болохыг байнга зөвлөдөг. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн гол үр дүн

⁵ Walker, J.R. (2010). Introduction to Hospitality Management (3rd edition). New Jersey: Pearson Education

⁶ Jenkins, C.L., & Henry, B. M. (1982), Government involvement in tourism in developing countries. Annals of Tourism Research, 9(4), 499-519.

нь ДНБ-нд эзлэх хувь, ажлын байр шинээр бий болгох гэсэн 2 үзүүлэлтээр илрэн гарч ирдэг байна (World Travel & Tourism Council, 2011)⁷.

Гурав. Монголын аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дүн

Аялал жуулчлалын салбарын хөгжлийн түүхээс

1954 онд Монголд “Жуулчин” компанийг гадаадын зочид, жуулчдыг хүлээн авах зорилготойгоор байгуулагдаад гол төлөв социалист улс орнуудаас жуулчид, зочид төлөөлөгчдийг хүлээн авч байсан. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн сүүлийн үе болох 1989 онд Монголд нийт 236 540 гадаадын зочин, төлөөлөгчид ирснээс 95 хувь нь Зүүн Европын коммунист дэглэмтэй улсуудаас иржээ (Koguba & Haraguchi, 1991⁸). 1990-ээд оноос эхэлсэн улс төр, эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээнд хувийн өмчид тулгуурласан олон тооны аялал жуулчлалын компаниуд шинээр байгуулагдсан.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед Монгол Улс эдийн засгийн гүнзгий хямралд орсноор инфляцийн түвшин эрс өссөн. 1990-1997 онуудад гадаадын жуулчин, зорчигчдын тоо эрс багассаныг доорх хүснэгтээс харж болно. (Хүснэгт 1-ийг үз). Монголын эдийн засаг, улс төрийн байдал тогтворгүй хямралтай байсан, эдийн засгийн суурь муу, гадаад орнуудад манай улсын тухай мэдээлэл бараг байгаагүй, дэд бүтэц хөгжөөгүй, аялал жуулчлалын салбар зах зээлийн эдийн засгийн шинэ орчинд сайн бэлтгэгдэж, хөгжиж чадаагүйгээс шалтгаалан жуулчдын тоо эрс буурсан юм.

Хүснэгт 1. Монголд ирсэн гадаадын зорчигчдын тоо 1989-2010

Жил	Зорчигчдын тоо	Өсөлтийн хувь
1989	218,723	
1990	147,000	-32.8
1995	110,000	-25.2
1997	82,000	-25.5
1998	135,000	64.6
1999	158,000	17.0
2000	158,250	0.2
2001	192,057	21.4
2002	230,138	19.8
2003	204,875	-10.9
2004	305,117	48.9
2005	338,725	11.0
2006	408,490	20.6
2007	454,762	11.3
2008	468,765	3.0
2009	464,850	-0.8
2010	553,175	19.9

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 1999-2010

Манай улсад ирэх гадаадын зорчигч, жуулчдын тоо 1998 оноос эхлэн эрчимтэй өсч эхэлсэн ч сүүлийн жилүүдэд энэ өсөлт аажмаар буурах хандлагатай байна. Үүнд 2009 оны дэлхийн эдийн засгийн хямрал тодорхой хэмжээгээр нөлөөлсөн ч манай улсын аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадвар олон улсын түвшинд төдийлөн өсөхгүй байгаа нь бас нэгэн чухал хүчин зүйл болжээ. Тухайлбал Дэлхийн эдийн засгийн форумаас гаргасан “Аялал, жуулчлалын өрсөлдөх чадвар 2011 он”-ы тайланг үзэхэд Монгол улс судалгаанд хамрагдсан 139 улсаас аялал жуулчлалын өрсөлдөх чадварын ерөнхий индексээр 101-р байрт (2009 онд 105-р байрт), аялал

⁷ World Travel & Tourism Council (WTTC). Travel & Tourism Economic Impact 2011

⁸ Kokubo & Haraguchi (1991), Mission report on advisory services for hotel management and the promotion of conventions in Mongolia. Ulaanbaatar: Economic and Social Commissions for Asia and the Pacific.

жуулчлалын бизнесийн орчин ба дэд бүтцээр 112-р байрт орсон аж. Жуулчны тоог тогтоохдоо 2000 онд батлагдсан Аялал жуулчлалын хуулийн заалтыг баримтлах болсон. Дараах хүснэгтэнд 2009-2010 онуудад ирсэн гадаадын жуулчдын тоог улсаар нь жагсаан харуулав.

Хүснэгт 2. Монголд ирсэн гадаадын жуулчдын тоо

Улсын нэр	2009	2010	Жилийн өсөлт, %	Нийт жуулчдын тоонд эзлэх хувь (2010)
БНХАУ	229 451	193 730	- 15,6	42,3
ОХУ	108 105	121 647	12,5	26,7
БНСУ	38 273	42 231	10,5	9,3
АНУ	11 344	12 808	10,3	2,8
Япон	11 401	14 140	24,2	3,1
ХБНГУ	6 687	8 095	21,1	1,8
Франц	6 706	7 527	12,2	1,7
Их Британи	5 872	6 209	5,7	1,4
Казахстан	5 053	5 757	13,9	1,3
Австрали	3 725	5 443	46,1	1,2
Бусад	66 219	38503	-41,9	8,4
Нийт	492 836	456 090		100

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2010

Манай улсад ирж байгаа жуулчдын дийлэнх буюу 70 хувийг (2010) ОХУ, БНХАУ-ын иргэд эзэлдэг ч тэд гол төлөв худалдаа, наймаа, ажлын хийх зорилгоор богино хугацаагаар орж ирдэг байна. Хэдийгээр тооны хувьд цөөн ч Европ, Хойд Америк, БНСУ, Японоос ирсэн жуулчид Монгол улсын аялал жуулчлалын салбарын орлогын ихэнхийг бүрдүүлдэг.

“Монгол Улсад Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар зарим арга хэмжээ авах” 167 тоот тогтоолыг Засгийн газар 1995 онд гаргаснаар төрийн зүгээс аялал жуулчлалын салбарыг дэмжих бодлогын эхлэлийг албан ёсоор эхлүүлсэн. Уг тогтоолын хүрээнд “Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл” ажлын хөтөлбөрийг баталсан бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлох, аялал жуулчлалын байгууллагуудад стандарт тогтоох, хууль эрх зүйн орчинг сайжруулах, аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны тогтолцоог боловсронгуй болгох талаар тодорхой зааж өгчээ. Уг салбарт батлагдсан гол баримт бичгүүдийн нэг “Аялал жуулчлалын тухай хууль”-ийг 2000 онд УИХ-аар баталж, аялал жуулчлалын нэр томъёо, аялал жуулчлалын салбар дахь төр, хувийн хэвшлийн харилцааг зохицуулах, аялал жуулчлалын байгууллагууд тэдгээрт тавигдах шаардлага, төрийн байгууллагын эрх, үүргийн талаар тодорхой тусгаж өгсөн байна. Түүнчлэн “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө” (1999), “Жуулчны баазын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага” (2002), “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага” (2004), “Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр” (2005), “Монгол улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги” (2007), “Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008), “Аялал жуулчлал үндэсний хөтөлбөр” (2011) зэрэгт манай улсын аялал жуулчлалын салбарын бодлого, эрх зүйн орчинг тодорхой хэмжээгээр бүрдүүлсэн байдаг. Дээрх бичиг баримтуудаас гадна “Монгол улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д (2008) 2015 он гэхэд манай улсад ирэх жуулчдын тоог 1 саяд хүргэснээр 2021 онд монголын хүн амтай ижил тоотой болгох зорилтуудыг тавьсан билээ. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 83-р тогтоолоор аялал жуулчлалын салбарыг тэргүүлэх салбар хэмээн тодорхойлсон.

Манай улсын хувьд төрийн байгууллагын зүгээс аялал жуулчлалын салбарт оролцож байгаа нэг үндсэн чиглэл нь гадаад сурталчилгааг дэмжих юм. Энэ хүрээнд Монголын аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, жуулчдад мэдээллийн үйлчилгээ үзүүлэх төвүүд байгуулах, WTM-London, ITB-Berlin, KOTFA-Seoul, JATA-Tokyo, CITM-Beijing, ITF-Taipеi зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд үндэсний аялал жуулчлалын компаниудыг нэгдсэн зохион байгуулалттай оролцуулах, жил бүрийн 12 сард олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг (ITF) өөрийн нутагт зохион байгуулах зэрэгт төрийн зүгээс идэвх санаачлага гарган ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөө, үр дүн

Манай улсад аялал жуулчлалын салбарын нийт орлогоор салбарын эдийн засгийн үр дүнг голлон хэмждэг. Үүний тулд манай улсын аялал жуулчлалын салбарт жуулчдын гаргаж байгаа зардлыг тооцож үзэх шаардлагатай. Өнөөдрийн байдлаар Зам, Тээвэр, Аялал Жуулчлалын Яамны сайдын 2002 оны тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Аялал жуулчлалын салбарын орлогыг тооцоолдог. Уг аргачлалаар Япон улсын нэг жуулчин Монгол Улсад дунджаар 8 хоног, хоногт дунджаар 126 ам. доллар, бусад улсын жуулчид дунджаар 12 хоног, өдөрт 106 ам.доллар, амралт, хувийн зорилгоор ирсэн жуулчид 15, хоног, өдөрт 42 ам.доллар, дамжин өнгөрүүлэх жуулчид дунджаар 5 хоног, өдөрт 42 доллар, бусад зорилгоор ирсэн жуулчид дунджаар 18 хоног, өдөрт 52 доллар зарцуулдаг гэсэн тооцоог үндэслэн салбарын орлогыг тооцдог байна. Сүүлийн жилүүдэд аялал жуулчлалын салбарын орлого байнга өсч ирсэн бөгөөд 2009 онд дэлхийн эдийн засгийн хямралаас шалтгаалан жуулчдын тоо эрс багассанаас болоод орлого ч буурсан (Хүснэгт 3 үз). 2010 оны байдлаар Монгол Улсын ДНБ нь 8,3 триллион төгрөгөөр хэмжигдэж байгаа юм (Үндэсний Статистикийн Хороо, 2011).

Хүснэгт 3. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

Жил	АЖ*салбарынорлого (сая.ам доллар)	АЖ салбарын орлогын өсөлт (%)	ДНБ (сая ам.доллар)	АЖ салбарын ДНБ оруулах хувь нэмэр (%)	ДНБ шууд хувь оруулах нийт хувь нэмэр** (%)
2005	170.0		2,306.0	7.4	12.9
2006	197.5	16.2	3,132.0	6.3	11,0
2007	227.1	15.0	4,235.0	5.4	9,4
2008	236.9	4.3	5,607.0	4.2	7,4
2009	213.3	-10.0	4,574.0	4,7	8,2
2010	224.4	5.2	6,125.0	3.7	6,4

*АЖ - Аялал жуулчлал гэсэн үгийн товчлол

** Үржүүлэгчийн утгыг 1,75 авав.

Эх үүсвэр: Аялал жуулчлалын үндэсний төв, Статистик мэдээлэл 2011, Монгол банк 2010, World Bank, World Development Indicators (2011)

Аялал жуулчлалын салбарын орлогын тооцоо нь зөвхөн гадаадын жуулчдаас олсон орлогын тооцоон дээр үндэслэдэг бөгөөд дотоодын аялал жуулчлалын салбарын орлогыг тооцсон судалгаа өнөөдөр ч байхгүй билээ. Энэ нь Монгол улсад жуулчид, тэдний орлого, зардлыг хэмждэг бүртгэл, тооцоо хөгжөөгүй байгааг харуулж байна. Аялал жуулчлалын салбарын ДНБ-нд эзлэх хувь төдийлөн өсөхгүй байгаа төдийгүй 2005 онд 7,4% байсан энэ үзүүлэлт 2010 онд 3,7% хүртэл буурчээ. Энэ нь уг салбарын эдийн засгийн цар хүрээ буурч байгаа хэрэг бус бөгөөд салбарын зах зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа ч эдийн засгийн бусад салбарууд, тухайлбал уул уурхайн үйлдвэрлэлийн салбар Монгол улсад илүү хурдацтай өсч байгаатай холбоотой ажээ.

Бид аялал жуулчлалын салбарын эдийн засагт, тэр дундаа ДНБ-нд эзлэх нийт хувийг гаргахдаа эдийн засгийн үржүүлэгчийн утгыг 1,75 гэсэн коэффициентээр тооцлоо. Өнөөдөр манай улсад аялал жуулчлалын эдийн засгийн үржүүлэгчийг тооцсон судалгаа байхгүйгээс олон улсын судалгааны дундаж үзүүлэлтийг авлаа (Walker, 2010⁹). Уг үзүүлэлтийг ашиглан аялал жуулчлалын салбарын ДНБ-д эзлэх хувийг тооцвол 2005 онд 12,5%, 2010 онд 6,4% гэсэн үзүүлэлт гарч байна. Уул уурхай Монголын эдийн засагт тэргүүлэх чиглэл байгаа үед аялал жуулчлалын ДНБ-д эзлэх хувийн жин цаашид ч буурсаар байх болно.

Монгол улс нэг салбараас, тэр дундаа богино хугацаанд шавхагдах нөөц бүхий уул уурхайн олзворлох салбараас илт хамааралтай эдийн засгийн эрсдэлтэй тогтолцооноос зайлсхийхийн тулд аялал жуулчлалын салбарыг бодлогоор хөгжүүлэх нь нэн чухал ач холбогдолтой юм. Хэдийгээр сүүлийн жилүүдэд өсөлтийн хурд нь буурч зогсонги байдалд орсон ч аялал

⁹ Walker, J.R. (2010). Introduction to Hospitality Management (3rd edition). New Jersey: Pearson Education

жуулчлалын салбар нь ажлын байрны багтаамж өндөртэй, хөдөө орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх өргөн боломжтой, бусад үйлчилгээний салбаруудыг дэмжих нөлөөтэй, шавхагдашгүй эдийн засгийн нөөц болон хөгжих боломжтойгоороо хөрөнгө оруулалт нэн түрүүнд хийх салбарын нэг билээ.

Хөрөнгө оруулалтын хэмжээ, түүний өгөөжийн түвшингээр аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг тооцдог бас нэгэн аргачлал дэлхий нийтэд түгээмэл хөгжсөн. Энэ талын судалгаа манай улсад байдаггүй. 2006 онд болсон Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын Аялал жуулчлалын салбар хуралдаан дээр тавьсан илтгэлдээ ЗТАЖЯ-ны сайд Ц.Цэнгэл “... Төрийн зүгээс Монгол орныг олон улсын аялал жуулчлалын сонирхол татсан бүс нутаг болгох зорилт дэвшүүлэн ажиллаж хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого барьж байна. Энэ хүрээнд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өвлийн болон тусгай сонирхлын аяллын зарим техник, хэрэгслийг импортоор оруулж ирэхэд гааль, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх шийдвэрүүдийг гаргасан. Өнөөдөр аялал жуулчлалын салбарын гол цөм нь хөдөө орон нутаг бөгөөд нийт жуулчлалын 90 хувь нь тэнд явагдаж байна. Одоогийн байдлаар 180 орчим жуулчны баазуудын 95 хувийг нь дотоодын хөрөнгө оруулалтаар байгуулсан” хэмээн ярьжээ. 2000-2005 онуудад аялал жуулчлалын салбарт оруулсан гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нь нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 1,1 хувийг эзэлж байгааг ЗТАЖЯ-ны 2006 оны статистик мэдээлсэн. Улсын хэмжээгээр 32 улсын 250 гадаадын хөрөнгө оруулалттай компани байгааг тогтоосон байна. (Хүснэгт 4-ийг үз).

Хүснэгт 4. Аялал жуулчлалын салбар дахь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд 2006 оны байдлаар

Улс	Хөрөнгө оруулалттай компаний тоо
БНСУ	82
Япон	31
БНХАУ	63
АНУ	13
ОХУ	17
Их Британи	6
ХБНГУ	5
Бусад	33
Нийт	250

Эх үүсвэр: Зам, Тээвэр, Аялал Жуулчлалын Яамны статистик мэдээлэл 2006

Манай улсын аялал жуулчлалын салбарт хамгийн олон компанийг өөрийн хөрөнгө оруулалтаар байгуулсан нь БНСУ байгаа нь хүснэгтээс харагдана. Түүнчлэн Япон, БНХАУ, АНУ, ОХУ нь аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулагч гол улсууд болж байна. Сүүлийн жилүүдэд олон улсын сүлжээ Шангри-Ла зочид буудал (Shangri La hotel), Рамада (Ramada hotel), Хан Палас зочид буудал (Kempinski hotel) зэрэг зочид буудлууд Монголд байгуулагдлаа. Хэдийгээр тооны хувьд гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд өсч байгаа ч тэдний эдийн засгийн цар хүрээ, хөрөнгө оруулалтын хувь хэмжээ хэвээр үлджээ.

Зах зээлийн эдийн засагт шилжих явцад манай улсын эдийн засаг гүнзгий хямралд автан улсын төсөв, гадаад худалдааны баланс байнга алдагдсанаас гадаад валютын хомсдолд байнга орж байсан хүнд хэцүү үед аялал жуулчлалын салбар нь гадаад худалдааны төлбөрийн балансын тэнцлийг хангах, цэвэр экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд зохих хувь нэмрээ оруулсаар ирсэн билээ. Аялал жуулчлал нь манай улсын нутаг дэвсгэр дээр явагдаж, гадаадад бараа, үйлчилгээг шууд гаргадаггүй ч эдийн засгийн мөн чанараараа экспортын бүтээгдэхүүнд тооцогддог. 2010 онд манай улсын гадаад худалдааны алдагдал 291,5 сая ам.доллар болсон бөгөөд аялал жуулчлалын салбараас олсон орлого 224,4 сая ам.доллараар хэмжигдэж байгаа нь нийт экспортын 7,7 хувийг эзэлж байна (Хүснэгт 5-ийг үз).

Хүснэгт 5. Аялал жуулчлалын салбарын орлого ба цэвэр экспорт

	сая.ам доллар				
Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010
Экспорт	1 542,8	1 947,5	2 534,0	1 885,4	2 908,5
Импорт	1 845,6	2 061,8	3 244,5	2 137,7	3 200,1
Цэвэр экспорт	-302,8	-114,3	-710,5	-252,3	-291,5
АЖ салбарын орлого	197,5	227,1	236,9	213,3	224,4
Экспортын хэмжээнд эзлэх АЖ салбарын орлогын хувь (%)	12,8	11,7	9,3	11,3	7,7

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2006-2010

2006-2010 онуудад аялал жуулчлалын салбарын орлого экспортын орлогын 10,6 (дунджаар) хувийг эзэлж байсан нь цэвэр экспортын алдагдалтай манай улсын хувьд энэхүү алдагдлыг нөхөхөд чухал хувь нэмэр оруулахуйц үзүүлэлт юм. 2007 онд цэвэр экспортын алдагдлаас аялал жуулчлалын салбарын орлого нь давж гарсан нь чухал үзүүлэлттэй байлаа.

Үндэсний Статистикийн Хорооны 2010 оны мэдээгээр аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг 426 байгууллагад 2079 хүн ажиллаж байна. 2009-2010 онд аялал жуулчлалын байгууллага болон ажилчдын тоо (ажилчид 13% -аар) буурсан байна. Үүнд аялал жуулчлалын салбарын өндөр улирал богино, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бага, эдийн засгийн бүтээмжийн өсөлт бараг байхгүй, зах зээлийн өсөлт сүүлийн жилүүдэд зогсонги байдалд орсон зэрэг хүчин зүйлүүд нөлөөлжээ.

Хүснэгт 6. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, ажиллагсдын тоо

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010
Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын тоо	418	403	493	472	426
Байгууллагын тооны өсөлт (%)		-3,6	22,3	-4,3	-9,7
Ажиллагчдын тоо	1796	1864	2033	2389	2079
Ажиллагчдын тооны өсөлт (%)		3,8	9,1	17,5	-13,0

Эх үүсвэр: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 2006-2010

Аялал жуулчлалын салбарт хамаарах үйл ажиллагаа бүхий аж ахуйн нэгжүүд, тэдний ажиллагсдын тоог авч үзвэл дээрх статистик өсөх бөгөөд улирлын чанартай, ажлын бүрэн бус цагаар ажиллаж байгаа хүмүүсийн тоог нарийвчлан тогтоосон судалгаа, мэдээлэл Монголд огт байхгүй. 2011 оны 3 сарын 28-нд зохиогдсон Аялал жуулчлалын үндэсний зөвлөгөөнд тавьсан илтгэлдээ Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхмийн Аялал жуулчлалын зөвлөлийн дарга Ш.Нэргүй аялал жуулчлалын салбарт 520 тур оператор, 340 жуулчны бааз, 326 зочид буудал, мэргэжлийн сургалт явуулдаг 40 гаруй их, дээд сургууль байгаа бөгөөд салбарын хэмжээнд 2000 орчим аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж 18000 орчим хүн ажиллаж байгааг цохон тэмдэглэсэн. Уг салбарт хамаарах төрийн бус байгууллагын тоо 40 хүрсэн байна. Тур операторууд дунджаар 5-30, жуулчны баазууд 10-25 ажилтантай хэмээн Ш.Нэргүй ярьжээ. Эдгээр статистикийг харахад Монголын аялал жуулчлалын салбар жижиг бизнес эрхлэгчдээс голлон бүрдэж байна гэсэн дүгнэлтийг хийж болохоор. Хөдөө, орон нутгийн иргэдийг аялал жуулчлалын үйлчилгээнд татан оролцуулах, тэдний орлогыг нэмэгдүүлэх, жуулчны баазуудыг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, орон нутагт ажлын байр бий болгох зэргээр орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, дэмжихэд аялал жуулчлал чухал ач холбогдолтой салбар юм.

Дээр олонтоо дурдсан зэрэг нөлөөг аялал жуулчлалын салбарт эдийн засаг үзүүлдэг ч нөгөө талаар нийгэм, эдийн засгийн олон сөрөг нөлөөтэйг хэлэх нь зүйтэй. Дэлхийд хүлэмжийн хий ялгаруулах нэг хэрэгсэл болох агаарын тээврийн хэрэглээг нэмэгдүүлэх, байгаль орчны

бохирдлыг өсгөхөд аялал жуулчлал шууд нөлөөлдөг. Түүнчлэн аялал жуулчлалын баазууд байршлын хувьд хэт ойрхноос зах зээлээ хуваах, эдийн засгийн үр ашиггүй үнийн өрсөлдөөнийг бий болгох, зарим аялал жуулчлалын компаниуд чанар муутай үйлчилгээ үзүүлдгээс салбарын нэр хүндийг олон улсын түвшинд унагаах, гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч орлого нь гадагш урсдагаас Монголын эдийн засагт наалдацгүй байх, аялал жуулчлалын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийн тэнцвэртэй хөгжлийг хангаж чадаагүйгээс хөрөнгө оруулалт оновчгүй болох, тухайн салбарын эдийн засгийн үр дүнг нэмэгдүүлэх талаар төрөөс дорвитой, бодит арга хэмжээ авахгүй байгаагаас “утаагүй үйлдвэрлэл”-ийн өсөлтийг эрчимжүүлэх эдийн засгийн бодит боломж, бололцоо алдагдсаар байна. Зохих түвшинд бэлтгэгдсэн чадварлаг хөтөч-тайлбарлагч дутагдалтай байгаагаас шалтгаалан мэргэжлийн бус гадаад хэлний орчуулагчид энэ ажлыг хийж байгаа нь Монгол улсад аялал жуулчлалын хүний нөөцийн бодлого алдагдсаныг, нөгөө талаас уг үйлчилгээ жуулчдад жинхэнэ утгаараа хүрч чадахгүй байгааг харуулж байна. Өнөөдрийн байдлаар аялал жуулчлалын салбарт төрийн болон хувийн хэвшлийн зүгээс эдийн засгийн бодит үр дүнг нэмэгдүүлэх оновчтой бодлого, гадаад улс орнуудын туршлагаас суралцан өөрийн орны нөхцөлд тохируулан нэвтрүүлэх, төрийн зохицуулалт хийх зэрэгт яаралтай шийдвэрлэх ёстой тулгамдсан асуудал олон байгаа бид хүлээн зөвшөөрөх цаг болжээ.

Дүгнэлт

Энэхүү өгүүлэлд аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг Монгол орны жишээн дээр авч үзэхийг зорьсон билээ. Аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг тооцох, түүний өгөөжийг нэмэгдүүлэх нь манай улсын эдийн засгийн хувьд хөгжлийн чухал ач холбогдолтой юм. Аялал жуулчлалын салбар нь Эдийн засгийн үр дүнгийн үүднээс авч үзвэл манай улсын аялал жуулчлалын салбар 1998 оноос өссөн үзүүлэлт гарна. 2010 оны байдлаар аялал жуулчлалын эдийн засгийн гол үр дүнгүүдийг тодорхойлбол салбарын орлого 224,4 сая ам.доллар, ДНБ-д эзлэх жин 3,7 хувьтай бөгөөд уг салбарт ажиллагсдын тоо 18000-д хүрчээ. Тус салбараас олсон орлого нь экспортын орлогын 7,7 хувьд хүрснээр гадаад худалдааны алдагдлыг нөхөхөд жинтэй хувь нэмэр оруулж байна. Салбарын хэмжээгээр өнөөдөр 520 тур оператор, 340 жуулчны бааз, 326 зочид буудал ажиллаж байгаагаас харахад сүүлийн 10 жилд аялал жуулчлалын салбар эрчимтэй өсөж байгаагийн тодорхой үзүүлэлт болно. Аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд салбарын хууль эрх зүйн зохицуулалтыг хангах, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг дэмжих, зарим чиглэлд татварын хөнгөлөлт үзүүлэх, гадаад сурталчилгааг явуулахад хувийн хэвшлийн компаниудыг дэмжин ажиллахад Монголын төр анхаарч ирсэн.

Аялал жуулчлалын салбарын олсон ололт амжилтыг дурдвал хэлэх, бичих зүйл арвин ч өнөөдөр уг салбар зогсонги байдалд орох төлөв ажиглагдаж байгаа нууц биш юм. Манай улс байгалийн болон соёлын аялал жуулчлалын нөөц, боломж ихтэй ч нөөцөө бүрэн дүүрэн эргэлтэнд оруулж чадахгүй байгаагаас эдийн засгийн бодит үр дүнг нэмэгдүүлэх боломжоо төдийлөн сайн ашиглаж чадахгүй байна. Өнөөдөр дэлхийд хамгийн хурдацтай өсч байгаа ирээдүйтэй салбар нь аялал жуулчлал мөнөөс мөн боловч манай улсын хувьд уг салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ бага, дотоодын аялал жуулчлалын зах зээлийг судлах, түүний үр дүнг нэмэгдүүлэх, хөгжүүлэх талаар ямар ч дорвитой арга хэмжээ төрийн зүгээс авахгүй байгаа билээ. Сүүлийн жилүүдэд улсын төсвөөс аялал жуулчлалын салбарт жилд дунджаар 150-300 сая төгрөг төсөвлөдгийн ихэнх нь сурталчилгааны үйл ажиллагаанд зарцуулагддаг аж. Аялал жуулчлалын эдийн засгийн нийт үр дүнг бүрэн тооцохын тулд дотоодын аялал жуулчлалын зах зээлийн хэмжээг тогтоох, мөн аялал жуулчлалын салбарын үржүүлэгчийн утгыг нарийвчлан судлах шаардлагатай байна. Дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын 2010 оны тайлан судалгаанд хамрагдсан 135 улсаас Монгол улс 105-д орж байгаа нь тухайн салбарын хөгжил сул байгааг харуулсан үзүүлэлт юм. Аялал жуулчлалын эдийн засгийн үр дүнг нэмэгдүүлэхийн тулд аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, хувийн

хэвшлийн байгууллагуудыг хөрөнгө оруулалт, зээлийн хөнгөлөлттэй нөхцлөөр дэмжиж өгөх, аялал жуулчлалын үйлчилгээний нэр төрөл, үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байгаа юм.

Ашигласан материал

Монгол хэлээр

1. Аялал жуулчлалын үндэсний төв, “Аялал жуулчлал” үндэсний хөтөлбөр /төсөл/ 2011 он.
2. Аялал жуулчлалын үндэсний төвийн вэб хуудас: www.mongoliatourism.gov.mn
3. БОАЖЯ, “БОАЖЯ-ны үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө” 2010-2013 он, 2010.
4. БОАЖЯ-ны вэб хуудас: www.mne.mn,
5. Жуулчны мэдээллийн төвийн вэб хуудас : www.touristinfocenter.mn
6. ЗТАЖЯ, “Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги” 2007 он.
7. Гансүх.Л, БОАЖЯ-ны сайд. “Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн чиглэл”. Аялал жуулчлалын үндэсний зөвлөгөөнд тавигдсан илтгэл, 2011 он.
8. Нэргүй.Ш, МҮХАҮТ-ийн Аялал жуулчлалын зөвлөлийн дарга. Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв. Аялал жуулчлалын үндэсний зөвлөгөөнд тавигдсан илтгэл. 2011 он
9. Монгол Улсын Засгийн Газар, Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл, 1995 он.
10. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, Монгол Улсын Статистикийн Эмхэтгэл 1999-2010 оны дугаарууд
11. Нэргүй.Ш, “Монголын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, хэтийн төлөв”. Аялал жуулчлалын үндэсний зөвлөгөөнд тавигдсан илтгэл. 2011 он.
12. УИХ, “Үндэсний хөгжлийн цогц бодлого”. 2008 он.
13. УИХ, Аялал жуулчлалын тухай хууль. 2000 он.

Англи хэлээр

14. Chris Cooper, John Fletcher, Alan Fyall, David Gilbert & Stephen Wanhill. Tourism: Principles and Practice, 4th edition. UK. 2008
15. Goeldner, C.R & Brent J.R (2009). Tourism: Principles, Practices, Philosophies. 11th edition. USA
16. Japan International Cooperation Agency (1999). Master plan on national tourism development in Mongolia. Ulaanbaatar: JICA
17. Jenkins, C.L., & Henry, B. M. (1982), Government involvement in tourism in developing countries. Annals of Tourism Research, 9(4), 499-519
18. Kokubo & Haraguchi (1991), Mission report on advisory services for hotel management and the promotion of conventions in Mongolia. Ulaanbaatar: Economic and Social Commissions for Asia and the Pacific
19. Sadraha, V, Sirakaya, E & Kerstetter, D (2002). Developing countries and Tourism Ecolabels, Tourism management, 23, 161-174
20. Tsengel, Ts (2006). The present situation of the tourism sector and investment opportunities in Mongolian tourism. Mongolian investment forum 2006, Ulaanbaatar
21. Walker, J.R. (2010). Introduction to Hospitality Management (3rd edition). New Jersey: Pearson Education
22. Weber, H. (2002). Travel to the land of Chingis Khan: Tourism development in Mongolia. HAS Newsletter, No.19, pp.1-2
23. World Economic Forum (2011). the Travel & Tourism Competitiveness Report 2011
24. World Tourism Organization (UNWTO). Available from online at <http://unwto.org/>
25. World Travel & Tourism Council (WTTC). Travel & Tourism Economic Impact 2011
26. World Travel & Tourism Council (WTTC). Available from online at www.wttc.org